

## ТӨМӨР ЗАМЫН ШУГАМЫН ДООД БҮТЦИЙН БАРИЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Энэхүү гэрээг Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, талуудын хүсэл зоригийг тус тус үндэслэн нэг талаас:

1. Нэг талаас Зэвсэгт хүчний Бүтээн байгуулалтын дэмжлэгийн газрын Зам, замын байгууламжийн хэлтсийн дарга, хурандаа Д.Энхцог  
Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх, 5-р хороо, энхтайваны өргөн чөлөө 51 хаягт байрлах, улсын бүртгэлийн 9068001032, регистрийн 8313962 дугаартай /цаашид "Захиалагч" гэх/
2. Нэг талаас "Ширхэнцэг хараа" ХХК-ийн гүйцэтгэх захирал Батсанаа овогтой Галсандолгор,  
Монгол Улс, Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, Туул гол, 87, 3/86 тоот хаягт байрлах, улсын бүртгэлийн 9011426036, регистрийн 5732476 дугаартай /цаашид "Гүйцэтгэгч" гэх/ нар /цаашид талууд/
  - 2.1.1 . Гүйцэтгэгчийн 2020 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 04 тоот албан бичиг,
  - 2.1.2 . Монгол Улсын Зам, тээврийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 315 дугаар тушаалаар байгуулагдсан Дэд ажлын хэсгийн 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 123 дугаар зөвлөмж,
  - 2.1.3 . 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 627 дугаар "Харилцан ойлголцлын санамж бичиг",
  - 2.1.4 . 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн "Улаан шугам хүлээлгэн өгсөн акт", зэргийг тус тус үндэслэв.

### ОРШИЛ ХЭСЭГ

1. Монгол Улсын Их Хурлын 2012 оны 32 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-д Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийг эхний үе шатанд барихаар заасан,
2. Засгийн газрын 2012 оны 121 дүгээр тогтоолын 1-д "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын 3.2.2-т заасан эхний үе шатанд барьж эхлэх төмөр замын суурь бүтцийг улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой төмөр замын суурь бүтэц ..." гэж заасан.
3. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2019 оны н05/05 дугаар зөвлөмж,
4. Засгийн газрын 2019 оны 135 дугаар тогтоол,
5. ТЕГ-ын 2019 оны н/476 дугаар зөвлөмж,
6. "Таван толгой-Зүүнбаян чиглэлийн шинэ төмөр зам төсөл"-ийг хэрэгжүүлэх ЗХЖШ-ын дарга, "Монголын төмөр зам" ТӨХК-ийн захиралтай 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан АГГ- Н/1901-МН/387 дугаар гэрээ,
7. ЗХББДГ-ын даргын 2020 оны А/17 дугаар тушаалаар батлагдан "Гэрээ байгуулах тусгай журам"
8. Монгол Улсын Иргэний хуулийн 189 дугаар зүйл, 343-358 дугаар зүйлийг тус тус үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож, **2020 оны 05 дугаар сарын 19-ний**

өдөр энэхүү гэрээг байгуулав.

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1.1 Гэрээний зорилго.

Гүйцэтгэгч нь Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын шугамын доод бүтцийн барилгын ажлыг гүйцэтгэж, ажлын гүйцэтгэлийг захиалагч талд гэрээнд заасан хугацаанд шилжүүлэх, захиалагч нь уг ажлыг санхүүжүүлэх хүсэлт “Монголын төмөр зам” ТӨХК-д олгох холбоотой захиалагч болон гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, эрх үүрэг, хариуцлагыг тогтооход оршино. Санхүүжилтийн харилцаа Монголын төмөр зам” ТӨХК-тай байгуулсан санхүүжилт олгох тухай гэрээгээр зохицуулна.

1.2 Захиалагч нь зардлыг гэрээнд заасан нөхцлийн дагуу олгохоос гадна нөгөө төлөөс гүйцэтгэгч тал нь ажлын гүйцэтгэлийг гэрээний зүйлээр тодорхойлж, хуваарыт төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн тохиолдолд гэрээний биелэлт хангагдана.

1.3 Гүйцэтгэгч нь гэрээний Хавсралт №5 -д заасан хугацаанд барилгын ажлыг, стандарт, норм, норматив, техникийн бичиг баримтын дагуу захиалагчийн хяналтын доор өндөр түвшинд гүйцэтгэхээс гадна харилцан хүсэл зоригоо илэрхийлсний үндсэн дээр тус гэрээнд заасан бүх нөхцлийг хүлээн зөвшөөрч, харилцан тохиролцов.

1.4 Гүйцэтгэгч гэрээнд заасан хугацаанд төлөвлөгөөт ажлыг хийж гүйцэтгээгүй тохиолдолд захиалагчийн урьдчилгаа төлбөрийг буцаан шилжүүлэх ба гэрээний хавсралтаар баталгаа гаргасан хөрөнгөөс Захиалагч үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар харилцан тохиролцсов.

1.5 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд ажил хэрэгч бүтээлч байж, хамтын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх, харилцан хүндэтгэлтэй байх зарчмыг баримтална.

## ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

### 2.1. Гэрээнд дурьдсан дараах нэр томьёог доорх байдлаар ойлгоно. Үүнд:

2.1.1. “Төсөл” гэж Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн шинэ төмөр зам барих төслийг;

2.1.2. “Төмөр замын доод бүтцийн барилгын ажил гүйцэтгэх гэрээ” гэж Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн шинэ төмөр зам төслийг хэрэгжүүлэх захиалагч, гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан тохиролцоог,

2.1.3. “Барилгын ажил” гэж энэхүү гэрээгээр Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэх “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын доод бүтэц барих ажлыг зураг төслийн дагуу гүйцэтгэх хавсралт №5-д заасан үйл ажиллагааг;

2.1.4. “Туслан гүйцэтгэх гэрээ” гэж энэ гэрээний Захиалагч талын хүлээн зөвшөөрсөн хуулийн этгээдүүдтэй байгуулсан гэрээ;

2.1.5. “Ажлын талбай” гэж байнгын болон түр ажил явагдаж байгаа орон зай, бараа, материалыг тээвэрлэх, хадгалах, ашиглах газар, ажлын талбайн нэг хэсэг гэж үзсэн гэрээнд заасан бусад газрыг;

2.1.6. “Захиалагч” гэж “Зэвсэгт хүчний Жанжин штаб” түүний эрх, үүрэг, хариуцлагыг шилжүүлэн авсан этгээд;

2.1.7. “Гүйцэтгэгч” гэж Захиалагчтай гэрээ байгуулан барилгын ажлын тодорхой хэсгийг гүйцэтгэж буй этгээдийг;

2.1.8. “Байнгын ажил” гэж Гэрээ болон зураг төслийн дагуу гүйцэтгэх барилгын ажлыг;

2.1.9. “Түр ажил” гэж Байнгын ажлыг хэвийн гүйцэтгэхэд шаардагдах туслах чанарын ажлыг;

2.1.10. “Зураг төсөл” гэж барилга байгууламжийн төлөвлөлт, техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, ажлын талбай, үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төсөл, инженер хайгуулын судалгаа, инженер геологи, геодезийн зураглал, барилгын төсөв зэрэг Хавсралт №3-т заасан баримт бичгийн иж бурдлийг;

2.1.11. “Зөвшөөрөл” гэж тусгай зөвшөөрөл, барилгын ажлын зөвшөөрөл, барилгын ажил гүйцэтгэх, бараа, материал тээвэрлэх, импортлох эсвэл экспортлох зорилгоор аливаа этгээдээс авах шаардлагатай зөвшөөрөл, тохиролцоо, баталгаа, эрх олголт, хэлцэл, татгалзаагүй тухай гэрчилгээ, эрхээсээ татгалзах, улсын комиссын ашиглалтад хүлээн авсан тухай гэрчилгээ зэргийг хэлэх бөгөөд үүнд бусдын газраар нэвтрэх эрх, газар худалдан авах, түрээслэх эрх олгох тухай гэрээг түүнчлэн ажил явуулахад нь саад тогтор үзүүлж болох (эсвэл гэрээ байгуулаагүйгээс Захиалагч эсвэл Гүйцэтгэгч уг ажил гүйцэтгэсний төлөө хариуцлага хүлээж болох) этгээдтэй байгуулах хэлцэл, зөвшилцэл багтана;

2.1.12. “Гүйцэтгэгчийн баримт бичиг” гэж Гэрээний дагуу Гүйцэтгэгчид шилжүүлсэн зураг төсөл, ажлын зураг, гарын авлага, гэрэл зураг, техникийн шинж чанартай өгөгдөл, ажлын гүйцэтгэлийн акт болон бусад баримт бичгийг;

2.1.13. “Хохирол” гэж эдийн ба эдийн бус хохирол байна. Эдгээрт хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, эрх, шаардлага, оюуны үнэт зүйлсийн өмчлөх, эзэмших, ашиглах эрх зорчигдэхийг;

2.1.14. “Барилгын болон инженерийн ажлын практик” гэж Монгол Улсыг оролцуулан бусад улсын төмөр замын салбарын инженер, зураг төсөл, тоног төхөөрөмж, худалдан авалт, барилгын ажил, үйлчилгээнд түгээмэл хэрэглэгддэг инженерийн сайн практик, арга, туршлагыг;

2.1.15. “Хамааралтай ажил” гэж Төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажлын талбай дээр болон түүний орчинд явуулж буй барилгын ажлаас бусад ажил, үйлчилгээг;

2.1.16. “Хамааралтай ажлын гэрээ” гэж хамааралтай ажлыг гүйцэтгүүлэхээр Захиалагч, Гүйцэтгэгч болон Хамааралтай ажлын гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээг;

2.1.17. “Хамааралтай ажлын гүйцэтгэгч” гэж Хамааралтай ажлыг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан этгээдийг хэлнэ.

2.1.18. “Ажил эхлэх өдөр” гэж Захиалагч ажил эхлүүлэх мэдэгдэлийг Гүйцэтгэгчид өгсөн өдрийг;

2.1.19. “Хоног” гэж хуанлийн хоногийг “жил” гэж гурван зуун жаран таван (365) хоногийг хэлнэ;

2.1.20. “Урьдчилан төлөвлөх боломжгүй” гэж Барилгын ажлын хуваарьт хугацаа эсвэл түүнээс өмнө Гүйцэтгэгчид урьдчилан харах, мэдэх боломжгүй нөхцөл байдал бий болохыг.

2.1.21. “Хяналтын байгууллага” гэж “Монгол Төмөр зам” ТӨХК-ийн томилсон “Таван толгой төмөр зам” ХХК-ийг.

## ГУРАВ. ГЭРЭЭНИЙ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ

3.1. Дараах баримт бичиг гэрээний хавсралт байх ба энэ нь гэрээний нөхцөлийн адил хүчин төгөлдөр, салшгүй хэсэг байна. Үүнд:

- 3.1.1. Хавсралт-1: Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар байгуулагдсан Ажлын дэд хэсгийн зөвлөмж;
- 3.1.2. Хавсралт 2: ЗХЖШ-ын дарга, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн захиралтай 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан АГГ- Н/1901-МН/387 дугаар гэрээ;
- 3.1.3. Хавсралт-3: Зураг төсөл;
- 3.1.4. Хавсралт-4: Барилгын төсөв;

- 3.1.5. Хавсралт-5: Барилгын ажил гүйцэтгэх календарчилсан төлөвлөгөө;
- 3.1.6. Хавсралт-6: Техникийн болон ажлын зураг, даалгавар, нөхцөл;
- 3.1.7. Хавсралт-7: Ажлын талбай, талбайн гадна хийгдэх бэлтгэл ажил, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангасан арга хэмжээг тусгасан төлөвлөгөө.
- 3.1.8. Хавсралт-8: Нууцын баталгаа.
- 3.1.9. Хавсралт-9: Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл.

## ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ

- 4.1. Гэрээний зүйл нь Тавантолгой-Зүүнбаян чиглэлд баригдах төмөр замын доод бүтцийн Хавсралт №3 зураг төсөл, Хавсралт №6-д заасан Техникийн болон ажлын зураг, даалгавар, нөхцөлийн дагуу төмөр замын шугамын доод бүтцийн бүрэлдэхүүн хэсэг, далан, хоолой зэрэг хиймэл байгууламжийг барих ажил байна.
- 4.2. Барилгын ажил гүйцэтгэх хамгийн үр ашигтай техник, технологийг сонгон ажиллах ба барилгын ажил гүйцэтгэх хугацааг богиносгож, барилгын чанарыг зураг төсөл, барилгын норм, дүрэмд заасан нормативт хэмжээнээс бууруулалгүй, барилгын төсөвт хөрөнгөнд багтаах, нөөц бололцоог ашиглах, хэмнэлтийн зарчмыг баримтлан ажиллана.
- 4.3. Тухайн ажлыг хариуцах инженер, техникийн ажилтныг томилсон тушаал гаргаж, энэ тухайгаа захиалангч талд албан ёсоор мэдэгдсэн байна.
- 4.4. Төмөр замын шугамын доод бүтцийн барилгын ажил нь дараах ажлыас бүрдэнэ.
  - 4.4.1. Газар шорооны ажил:
    - 4.4.1.1. Хэмжилтийн ажил;
    - 4.4.1.2. Ургамлын үе хуулах;
    - 4.4.1.3. Далангийн ажил;
    - 4.4.1.4. Суурийн ажил
    - 4.4.1.5. Ухмалын ажил /ухмалын хамгаалалт, ухмалын шуудуу/;
    - 4.4.1.6. Уулын болон өөрийн шуудуу;
    - 4.4.1.7. Технологийн зам;
    - 4.4.1.8. Шороон орд нээх, нөхөн сэргээх;
    - 4.4.1.9. Ухмал, далангийн хажуу налуугийн бэхэлгээ /зураг төсөлд тусгагдсан заагдсан бол/;
    - 4.4.1.10. Далангийн гарц, орц;
    - 4.4.1.11. Талбайн цэвэрлэгээ /далан, ухмалын хажуу налууг татах/;
    - 4.4.1.12. Хамгаалах далан /зураг төсөлд тусгагдсан заагдсан бол/;
    - 4.4.1.13. Лабораторийн туршилт, шинжилгээ;
- 4.5. Гэрээний дагуу гүйцэтгэх ажлын цар хүрээ:  
Барилгын ажлыг зохих зөвшөөрөл, зураг төсөл, стандарт, техникийн нөхцөлийн дагуу гүйцэтгүүлэх, барилгын үе шатны ажлын явцад хяналт тавих, гүйцэтгэлийг хянан баталгаажуулах, барилгын ажлыг хүлээлгэн өгөх зэргээс бүрдэнэ.
- 4.6. Барилгын ажлыг холбогдох Монгол Улсын хууль тогтоомж, барилгын норм, дүрэм, журам, заавар, үндэсний болон олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн эрх бүхий төрийн байгууллагаар хүлээн зөвшөөрөгдөхүйц үр дүнтэй гүйцэтгэнэ.
- 4.7. Барилгын ажлын гүйцэтгэлтэй холбоотой зураг төсөл, хавсаргасан баримт бичиг, мэдээлэл, фото болон схем зураг, диаграм, бусад холбогдох дагалдах зүйлс нь Захиалагчийн өмчлөлд байна.
- 4.8. Түр ажил нь Гүйцэтгэгчид барилгын ажлыг байнга, хэвийн тасралтгүй, аюулгүй гүйцэтгэхэд шаардлагатай түр зуурын барилга байгууламж, ажил, үйлчилгээ /кэмп барих, нүүлгэн шилжүүлэх, технологийн зам барих, ашиглах, тэмдэг, тэмдэглэгээ хийх, бараа, материал хадгалах, ашиглах, тээвэрлэх, хог хаягдлыг зайлцуулах, хаалт, хашилага, харуул

хамгаалалтын ажил ба үүгээр хязгаарлагдахгүй бусад/-г багтаасан байна.

4.9. Барилгын ажилд ашиглаж байгаа стандарт өөр хоорондоо зөрчилдөх тохиолдолд хамгийн үр ашигтай, чанартай тохиромжтой стандартыг Захиалагчийн хяналтын инженерийн зөвшөөрлийн дагуу хэрэглэнэ. Үүнтэй холбоотой зардал болон хугацаа нэмэгдэхээр бол талууд харилцан зөвшилцэж тохиролцсоны дараа ажлыг гүйцэтгэнэ.

4.10. Гэрээнд заасан ажлыг гүйцэтгэгч тал тогтоосон хугацаанд хийж гүйцэтгээгүй болон ажлын явцын дундаас гэрээний үүргээс татгалзсан, хугацаа хэтрүүлсэн, зөрчил гаргасан, техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангаагүйгээс гүйцэтгэгч тал аливаа зөрчил гаргах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд үл маргах журмаар барьцаа хөрөнгөөс гаргуулах, үүргийн гүйцэтгэлийг ханглулахаар шаардах эрхтэй болохыг талууд тохиролцов.

#### ТАВ. ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ

5.1. Гүйцэтгэгч нь гэрээний үүргээ бүхэлд нь эсвэл хэсэгчлэн эсвэл энэхүү гэрээтэй холбоотой аливаа үйлдэл хийх эрхийг захиалагчийн зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

5.2. Захиалагч нь ажил гүйцэтгүүлэх шаардлагаар гүйцэтгэгчийн зөвшөөрөл шаардахгүйгээр энэ гэрээтэй холбоотой аливаа үйлдэл хийх, гэрээний эрх, үүргээ бүрэн эсхүл хэсэгчлэн төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрлэсний дагуу өөр этгээдэд шилжүүлж, даалгаж эсвэл барьцаалж болно.

#### ЗУРГАА. БАРИЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

6.1. Барилгын ажлыг гэрээний хавсралт №5-т заасан хугацаанд хийж гүйцэтгэж, захиалагчид хүлээлгэн өгөх үүрэг хүлээнэ.

**Ажлын эхлэх хугацаа 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдөр**

**Хүлээлгэн өгөх хугацаа 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдөр байх ба ажлын үргэлжлэх хугацааг Хавсралт №5-д заасан нарийвчилсан хугацаагаар тогтооно. Талууд гэрээний хугацааг чанд мөрдөн ажиллана.**

6.2. Давагдашгүй хүчин зүйлээс бусад тухайлбал, ажил гүйцэтгэгчийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, ажил гүйцэтгэхэд шаардлагдах техник тоног төхөөрөмжийг тээвэрлэхэд гарсан аливаа saat ал, эрсдэл, энэ гэрээнд заасны дагуу ажлын гүйцэтгэлийн доголдлыг арилгасан зэрэг нь ажил гүйцэтгэх хугацаагаа өөрчлөх, хойшилуулах үндэслэл болохгүй.

6.3. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй тал хууль болон гэрээнд зааснаар алданги болон торгууль ногдуулах үндэслэл болно. Алдангийн хэмжээг хавсралт №4-т заасны дагуу зохицуулах болно.

6.4. Давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдлын улмаас гэрээт ажлын гүйцэтгэл тасалдсан, saatсан тохиолдолд гүйцэтгэгчийг хугацаа хэтрүүлсэнд тооцохгүй бөгөөд үйл ажиллагаа зогссон, saatсан хугацаагаар гэрээт ажлын хугацаа сунгагдана.

6.5. Гэрээт ажлын хуваарь, зураг төсөл, төсөвт тусгагдаагүй боловч норм, дүрэм, стандартын дагуу зайлшгүй хийх шаардлагатай ажилбар гарсан, түүнчлэн зураг төслийн алдаанаас шалтгаалан нэмэлт ажиллагаа хийгдэх болсоны улмаас гүйцэтгэлийн хугацаа нэмэгдэхээр бол гүйцэтгэгч тал энэ талаар захиалагчид бичгээр мэдэгдэж шийдвэрлүүлнэ.

6.6. Ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй тохиолдолд захиалагч ажлын тоо хэмжээг багасгах, бие даан гэрээг цуцлах эрхийг үл маргах журмаар эдлэнэ.

#### ДОЛОО. ТӨЛБӨР ТООЦОО ХИЙХ ЖУРАМ

7.1. Энэхүү гэрээгээр гүйцэтгэх барилгын ажлын төсөвт хавсралт №4-д зааснаар зохицуулагдана.

7.2. Захиалагч, хяналтын байгууллагын эцэслэн баталгаажуулсан тоо хэмжээгээр



гүйцэтгэлийг нэхэмжлэх эрх үүснэ.

7.3. Ажлын тоо хэмжээ ессөн болон буурсан үзүүлэлтээс шалтгаалан гэрээгээр тохиролцсон үнэнд өөрчлөлт орно.

7.4. Гэрээний нийт үнэ гэж хавсралт №4-т заасан үнийг ойлгох ба Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын шугамын доод бүтцийн барилгын ажил болох гэрээний 4.4-т заагдсан ажлын төсөвт өртөг, ажлын техникийн даалгаварт заасны дагуу Захиалагчид бүрэн хүлээлгэн өгөхөд шаардагдах бараа, ажил, үйлчилгээтэй холбогдон гарах бүх зардал, татвар, хураамж /аж ахуйн нэгжийн орлогын, нэмэгдсэн өргтийн/ багтсан. Үүнд: гүйцэтгэлийн зураг төсөл, гүйцэтгэлийн тайлан, судалгаа, бүх төрлийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тэдгээрийн ашиглалтын зардал, удирдлагын болон үйл ажиллагааны зардал, цалин хөлс, захиалагчийн хяналт, шалгалтын зардал, үндсэн ажлын болон технологи ашиглалтын зардал, туслан гүйцэтгэгчийн ажлын хөлс, бараа материал, техник, тоног төхөөрөмж худалдан авах өртөг, тээвэр, тэдгээрийн ашиглалт болон түрээсийн зардал, нүүлгэн шилжүүлэлт, магадлашгүй ажлын зардал, төлбөр, хураамж, шимтгэл, байгаль орчны нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зардал, бүх төрлийн даатгалын хураамж, түр зогсолт, баталгаат хугацааны зардал, барьцаа болон барьцаалбарын зардал, ажилчдын хээрийн нэмэгдэл, хувцас хэрэглэл, зэрэг холбогдох бусад хариуцлага, нийтлэг эрсдэл болон үүрэг зэрэг шууд нэрлэн заасан болон нэрлээгүй нийт өртөг, бүх төлбөр зардал багтсан болно.

7.5. Гэрээ батлагдаж ажил эхэлснээр гүйцэтгэх ажлын төсөвт өргтийн 10 хүртэлх хувийн урьдчилгаа санхүүжилт олгож болно.

7.6. Ажлын гүйцэтгэлийн 50 хүртэлх хувийн гүйцэтгэлээс урьдчилгаа төлбөрийг, 70 хүртэлх хувийн гүйцэтгэлээс суутган тооцох бусад зардлыг бүрэн суутгаж барагдуулсан байна.

7.7. Ажлын гүйцэтгэлийн тоо хэмжээг захиалагчийн тоо хэмжээний инженер, төслийн хяналтын байгууллагууд, үндсэн захиалагч "Монголын Төмөр зам" ХХК, гэрээний дагуу төлөх үнэ, хөлсийг үндсэн захиалагч "Монголын Төмөр зам" ХХК, захиалагчийн төсөвчин, санхүүгийн хэлтэс баталгаажуулна.

7.8. "Ажил гүйцэтгэх гэрээний гүйцэтгэлийн санхүүжилтийг Зэвсэгт хүчний ББДГ-ын санхүүгийн хэлтсээс ирүүлсэн төлбөрийн хүсэлт, ажлын гүйцэтгэл, нэхэмжлэхийг үндэслэн "Монголын төмөр зам" ТӨХК нь "Санхүүжилт олгох гэрээ"-ний үндсэн дээр шийдвэрлэнэ. Монголын Төмөр замтай байгуулсан "Санхүүжилтийн гэрээ" нь бие даасан шинжтэй байна.

7.9. Ажил гүйцэтгэх гэрээг хэрэглэх явцад санхүүжилттай холбоотой асуудал, түүнээс үүсэн гарах үр дагавар аливаа хариуцлагыг зөвхөн санхүүжилт олгох гэрээгээр зохицуулна.

7.10. Эрх бүхий албан тушаалтнаар баталгаажаагүй, гарын үсэг дутуу ажлын гүйцэтгэл, үнийн дүн, тоо хэмжээ зөрүүтэй нэхэмжлэхээр гүйцэтгэгчээс төлбөр хийхийг шаардах, захиалагчаас санхүүжилт хийхийг хориглоно.

## НАЙМ. БАРИЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭЛД ТАВИХ ХЯНАЛТ

8.1. Барилгын ажлын гүйцэтгэлд Захиалагчийн инженер, хяналтын байгууллага нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, зааврын дагуу хяналт тавина.

8.2. Гүйцэтгэгч нь барилгын ажлыг гүйцэтгэхдээ холбогдох байгууллагуудаас олгосон зөвшөөрөл, магадлагдсан зураг төслийн дагуу зохих ёсоор гүйцэтгэж, ажлын гүйцэтгэл дотоод хяналтыг тавьж ажиллана.

8.3. Захиалагч нь дараах баримт бичгийг шалгаж, барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавина. Үүнд:

8.3.1. Зураг төсөл

8.3.2. Барилгын ажил гүйцэтгэх календарчилсан төлөвлөгөө;



- 8.3.3. Үе шатны ажлын төлөвлөгөө, ажлын хуваарь;
- 8.3.4. Хууль тогтоомж ба стандартын шаардлага;
- 8.3.5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй;
- 8.3.6. Байгаль орчныг хамгаалах шаардлага;
- 8.3.7. Шаардлагатай гэж үзсэн бусад.
- 8.4. Захиалагийн хяналт /инженер/ эсхүл хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлэгч этгээдээр дамжуулан барилгын ажлын чанарын хяналтад дараах үүрэгтэй оролцно. Үүнд:
- 8.4.1. Гүйцэтгэгчийн дотоод хяналт хэрэгжүүлэгч нэгж, чанарын албатай харьцаж ажиллах, гүйцэтгэж байгаа ажлын тоо хэмжээ ба хугацаа нь гэрээний графиктай нийцэж байгаа эсэх;
- 8.4.2. Барилгын технологи, зохион байгуулалтын баримт бичгийн бүрдэл, ажлын талбайн зохион байгуулалт, харуул хамгаалалт, инженерийн түр шугам сүлжээг барилгын норм, дүрмийн дагуу байгуулсан байдалтай танилцах, хянах, зохих шаардлага тавих;
- 8.4.3. Барилгын материал, бүтээц, тоног төхөөрөмжийг холбогдох стандарт, техник, технологийн шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;
- 8.4.4. Барилгын материал, тоног төхөөрөмжийг агуулах талбайд хадгалалтын байдал, барилгын норм, дүрэм, стандартын шаардлагыг зөрчиж хадгалсан байвал алдааг засч, запруулах, хадгалалтаас болж гэмтсэн материалыг хэрэглэхийг хориглох ба хариуцлага тооцуулах;
- 8.4.5. Барилгын ажлын явцад зураг төсөлд илэрсэн алдааг засуулах, зассан зураг төслийг хянан хүлээн авч гүйцэтгэгчид хүлээлгэн өгөх,
- 8.4.6. Орон нутгийн захиргаа, хяналтын байгууллагаас гүйцэтгэгчид тавьсан мэдэгдэл, шаардлагын биелэлтэд шуурхай хяналт тавих, хамтран ажиллах;
- 8.4.7. Барилгын ажлыг хүлээн авах болон барилгын ажил болон объектын чанарт ерөнхий үнэлэлт дүгнэлт өгөх.
- 8.5. Ажлын гүйцэтгэлд хяналт тавих зорилгоор Захиалагч нь дараах эрх эдэлнэ. Үүнд:
- 8.5.1. Ажлын талбайд нэвтрэх, ажлын явцыг газар дээр нь үзэж шалгах, дүрс бичлэг болон фото зургаар баталгаажуулах;
- 8.5.2. Хөндлөнгийн шинжээч томилон ажиллуулах, дүгнэлт гаргуулах;
- 8.5.3. Шаардлагатай тайлбар, мэдээлэл, баримт бичгийг туслан гүйцэтгэгчээс гаргуулан авах;
- 8.5.4. Захиалагч нь ажлын явц, гүйцэтгэл, чанарыг үе шат болон хугацаанд хамтран шалгаж баталгаажуулах;
- 8.5.5. Ажлын гүйцэтгэл зураг төсөл, хавсралтын дагуу эсэхийг хянах, баталгаажуулах;
- 8.5.6. Ажилд ашиглагдаж байгаа бүх терлийн материал, тоног төхөөрөмж, тэдгээрийн тоо хэмжээ, чанарыг шалгах, бүртгэх, холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм, журамд нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах;
- 8.5.7. Аюулгүй ажиллагааны стандарт, журмын үйлчлэлд хяналт тавих.
- 8.6. Ажлын гүйцэтгэлийг хамтран шалгаж баталгаажуулахдаа хамтарсан тэмдэглэл үйлдэж, ийнхүү шалгасан эрх бүхий албан тушаалтууд гарын үсэг зурж баталгаажуулна.
- 8.7. Ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр ажил гүйцэтгэх нарийвчилсан хуваарийг гүйцэтгэгч гарган мөрдүүлж болно.
- 8.8. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний дагуу ажлыг гүйцэтгэхдээ хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллагын явцын болон үе шатад хяналтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хийлгэнэ.

#### ЕС. АЖЛЫН ДОГОЛДОЛ, ТҮҮНИЙГ АРИЛГАХ

- 9.1. Барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавих, үзлэг, шалгалт, хэмжилт, туршилт

явуулсны үр дүнд барилгын ажилд ашигласан материалын аливаа хэсэгт эсвэл гүйцэтгэсэн ажлын тоо, хэмжээ, чанар нь зураг төслийн шаардлагад нийцэхгүй байвал доголдолтой гэж үзнэ.

9.2. Ажлын гүйцэтгэлийн доголдол илэрсэн тохиолдолд Захиалагч болон Хяналтын байгууллагаас учир шалтгааныг тодорхой заасан мэдэгдэлийг тухай бүрт гүйцэтгэгчид өгч, Гүйцэтгэгч доголдлыг арилгах арга хэмжээг заасан хугацаанд хэрэгжүүлнэ.

9.3. Гүйцэтгэгч нь ажлын үр дүнгийн доголдлын талаар санаатай нуун дарагдуулсан нь хожим илэрвэл хариуцлагаас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөгдөх үндэслэл болохгүй бөгөөд захиалагч, бусад этгээдэд учирсан шууд болон шууд бус хохирлыг бүрэн хариуцаж, нөхөн төлнө.

9.4. Гүйцэтгэгч нь гэрээний нөхцөлийг зөрчсөн буюу гүйцэтгэсэн ажилд ямар нэг доголдол илэрвэл ажлыг хүлээн авсанаас хойш 3 жилийн дотор Захиалагч энэ тухай гомдлын шаардлага гаргах эрхтэй.

9.5. Ажил гүйцэтгэх үйл ажиллагаатай холбоотойгоор Захиалагч нь Гүйцэтгэгчид дараах мэдэгдэл өгнө. Үүнд:

9.5.1. Гэрээний дагуу шаардлага хангахгүй аливаа материалыг ажлын талбайгаас гаргуулах, солиулах;

9.5.2. Ажлын доголдлыг арилгуулах талаар зөвлөмж, шаардлага хүргүүлэх.

#### **АРАВ. ХУУЛЬ ТОГТООМЖ, ГЭРЭЭГ ТАЙЛБАРЛАХ**

10.1. Гэрээний зүйл, хэсэг, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлахад бөгөөд хэрэв энэ гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана.

10.2. Гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлахад боломжгүй тохиолдолд гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Монгол Улсын хуульд нийцүүлэн тайлбарлана.

10.3. Захиалагч, гүйцэтгэгч болон аливаа бусад этгээдийн хооронд байгуулсан гэрээ гэсэн ойлголтод нэмэлт, өөрчлөлт, хавсралт, орчуулга, иноваци, эрх шилжсэн байдлууд хамаарна.

#### **АРВАН НЭГ. БАРИМТ БИЧГИЙГ ХАДГАЛАХ БОЛОН ШИЛЖҮҮЛЭХ**

11.1. Гүйцэтгэгчийн бүрдүүлсэн баримт бичиг бүрийг Захиалагчид шилжих хүртэл Гүйцэтгэгч хадгална. Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгчийн баримт бичиг тус бүрийг турван хувийг /эх хувь-2, цахим хувь-1/ Захиалагчид хүлээлгэн өгнө.

11.2. Гүйцэтгэгч нь захиалагчид шилжүүлсэн баримт бичгийг оролцуулан Гэрээгээр хүлээсэн үүрэгтэй холбоотойгоор олж авсан, өөрөө бий болгосон эсвэл өөрийн нэрийн өмнөөс хийлгэсэн бичгээр үйлдсэн бүх баримт бичиг, зураг, график материал, гэрэл зураг болон бусад бүх мэдээлэлд нэвтрэх, ашиглах, хуулбарлах боломжоор Захиалагчийг хангана.

11.3. Барилгын ажилд ашиглагдсан зураг төсөл, барилгын төсөв, судалгаа, туршилт, дүгнэлт болон бусад холбогдох баримт бичиг захиалагчийн өмч байна.

#### **АРВАН ХОЁР. НУУЦЛАЛ, НУУЦЫГ ХАДГАЛАХ**

12.1. Талууд, тэдгээрийн ажилтан гэрээний хэрэгжилттэй холбоотой аливаа баримт бичиг, мэдээллийг харилцан дамжуулах, хадгалах, хамгаалах, солилцохдоо “Төрийн болон албаны нууцын тухай” хууль бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг чанд мөрдөн ажиллана.

12.2. Гэрээг төлөөлөн байгуулж байгаа этгээдүүд гэрээний Хавсралт №8-ын дагуу нууцын баталгаа гарана.

12.3. Талууд энэхүү гэрээний нөхцөл, барилгын ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор шууд ба шууд бусаар, мөн гэрээ байгуулахаас өмнө эсвэл хойно /цуцласны дараа нэгэн адил/

өгсөн эсэхийг үл хамааран нууц мэдээ, мэдээлэл, баримт бичгийн нууцлалыг чанд хадгалж, захиалагч талын зөвшөөрөлгүйгээр аливаа гуравдагч этгээдэд задруулахыг хориглоно.

12.4. Энэхүү гэрээний 12.1, 12.3 дахь заалтуудыг зөрчсөн тал нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

12.5. Гүйцэтгэгч нь нууцлагдсан баримт бичигтэй танилцах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд нууцын баталгаа гаргуулан танилцана.

### **АРВАН ГУРАВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ДАГУУ АЖИЛЛАХ**

13.1. Гүйцэтгэгч нь төмөр замын доод бүтэц барих тусгай зөвшөөрөлтэй байх бөгөөд ажил гүйцэтгэхэд шаардагдах зөвшөөрлүүдийг заавал авсан байна.

13.2. Барилгын ажлыг гүйцэтгэх явцад шаардагдах ус, бохир ус, хий, цахилгаан болон холбоо, түгээмэл дархацтай ашигт малтмал хайх, ашиглах зөвшөөрөлтэй холбоотой асуудлыг Гүйцэтгэгч бие даан зохион байгуулах ба Захиалагч үүрэг, хариуцлагыг хүлээхгүй.

13.3. Гүйцэтгэгч нь зохих зөвшөөрөл тус бүрийг тогтоосон хугацаанд эсвэл түүнээс өмнө авах, мөн барилгын ажлын явцад аливаа саатал гаргахаас урьдчилан сэргийлж, тогтоосон хугацаанд багтаан зөвшөөрлийг авна.

13.4. Гүйцэтгэгч нь бусад нэр заагдаагүй, зайлшгүй шаардлагатай зөвшөөрлийг гэрээнд заасан үргийн дагуу тогтоосон хугацаанд багтаан авсан байна.

### **АРВАН ДӨРӨВ. ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ АЖИЛЛУУЛАХ**

14.1. Гүйцэтгэгч нь өөрийн хүчээр гүйцэтгэх боломжгүй барилгын ажлыг Захиалагчтай зөвшилцсений үндсэн дээр мэргэжлийн туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болно. Энэ тохиолдолд гүйцэтгэгч нь захиалагчийн хувьд ерөнхий гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн хувьд захиалагч болно.

14.2. Гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгчийн ажлын үр дүнт Захиалагчийн өмнө бүрэн хариуцна.

14.3. Захиалагч нь энэхүү гэрээний дагуу туслан гүйцэтгэгчийн өмнө аливаа үүрэг хүлээхгүй.

14.4. Гүйцэтгэгч нь Захиалагчаас бичгээр өгсөн зөвшөөрөл авалгүйгээр барилгын ажлын аливаа хэсгийг эсхүл бүхэлд нь туслан гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж үл болно.

14.5. Гүйцэтгэгч нь аливаа Туслан гүйцэтгэгчийн гаргасан зөрчил, доголдлыг Захиалагчийн өмнө бүрэн хариуцна.

14.6. Туслан гүйцэтгэгч нь хуульд заасан тусгай зөвшөөрөлтэй, санхүү, ажиллах хүн хүч, техник, тоног төхөөрөмжийн чадвартай хуулийн этгээд байх ба Монгол улсын хууль тогтоомж, үндэсний болон олон улсын стандартад нийцүүлэн барилгын ажлыг үр дүнтэй гүйцэтгэх үүрэг хүлээнэ.

### **АРВАН ТАВ. ЗАХИАЛАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЭРХ ҮҮРЭГ**

15.1. Захиалагч нь гэрээний дагуу захиалагчийн хяналтын чиг үүргийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар болон энэ гэрээний дагуу хэрэгжүүлнэ;

15.2. Төмөр замын шугамын доод бүтцийн барилгын ажлын батлагдсан зураг төслийг гаргаж гүйцэтгэгчид хүлээлгэн өгөх;

15.3. Барилгын ажил, үе шатанд хяналт тавих, шалгах, нягтлах, зааварчлах, санал тавих, туршилт явуулах, зөвшөөрөл өгөх, баталгаажуулах, илэрсэн зөрчил, доголдлыг арилгуулах арга хэмжээ авах, шаардлага тавих, гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ авах, зохиогчийн хяналт хийлгэх, хөндлөнгийн байгууллагаар шинжилгээ хийлгэх, үнэлэлт, зөвлөмж өгнө.

- 15.4. Захиалагч нь төмөр замын доод бүтцийн барилгын ажлын гүйцэтгэлийг зохих шаардлага хангасан, үндэслэл бүхий хүсэлт, барилгын төсөв, нэхэмжлэхийн хамт тогтоосон хугацаанд хүлээн авах, хянан баталгаажуулсаны үндсэн дээр санхүүжилт олго асуудлыг шийдвэрлэх, бүхэлд нь болон хэсэгчлэн санхүүжүүлэх арга хэмжээ авах.
- 15.5. Захиалагч нь зохих шаардлага хангаагүй, үндэслэлгүй төсвийн санхүүжилтийн хүсэлтийг дахин хянаж үзэх, тодруулга авах, тоо хэмжээг өөрчлөх эрхтэй бөгөөд үүний улмаас үүсэх үр дагаврыг хариуцахгүй.
- 15.6. Захиалагч нь зураг төсөл, ажлын тоо хэмжээ, барилгын төсвийг өөрчлөх тохиолдолд Гүйцэтгэгчид мэдэгдэж, түүнтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр барилгын төсөвт өөрчлөлт оруулах, нэмэлт зардал, үнийн зөрүү, ажил гүйцэтгэх хугацааны талаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.
- 15.7. Төмөр замын шугамын доод бүтцийн барилгын ажлыг хүлээн авахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулна.
- 15.8. Барилгын ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй, дутуу гүйцэтгэсэн, ашиглалтад оруулаагүй, стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн дагуу ашиглалтын бэлэн байдлыг хангаагүй, орон нутгийн иргэд болон байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөг арилгах талаар эрх бүхий этгээдээс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй бол зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоох, тухайн хугацаанд шаардлагыг биелүүлээгүй бол гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.
- 15.9. Барилгын төсвийн хэмжээ нэмэгдсэнээс захиалагч нь гэрээг дуусгавар болгохоор шийдвэрлэсэн бол гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид Хавсралт №4-д заасан хэмжээгээр төлөх үүрэгтэй.
- 15.10. Ажлын эцсийн гүйцэтгэлийг хүлээн авах үед түүний доголдлыг мэдэх боломжгүй байсан бол энэ талаарх гомдлын шаардлагыг чанарын баталгаат хугацааны дотор гаргах эрхтэй.
- 15.11. Захиалагч нь зураг төсөл, бодит тоо хэмжээний алдаанаас үүдэлтэй гүйцэтгэлийн хугацааны болон төсвийн өөрчлөлтийн дагуу шуурхай шийдвэрлэх үүрэгтэй.
- 15.12. Гэрээгээр хүлээсэн үүргээ тогтоосон хугацаанд чанартай, бүрэн биелүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардах, сануулах, гэрээний үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй бол гэрээг бие даан цуцлах эрхтэй.
- 15.13. Ажлын гүйцэтгэлийн шалгалтын явцад илэрсэн чанаргүй, дутуу, буруу хийсэн ажлын гүйцэтгэлийг хугацаа тогтоон засаж хийхийг шаардах эрхтэй.
- 15.14. Гүйцэтгэгчид гэрээгээр тохиролцсон үнийг төлөх үүрэг хүлээнэ.
- 15.15. Гүйцэтгэгчээс ажлын үр дүнг хугацаанд нь хүлээн авах, шаардах бүрэн эрхтэй.
- 15.16. Гүйцэтгэгчид энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлэхэд шаардагдах бүхий л мэдээллээр хангах, санал солилцох, зааварчилгаа өгөх.
- 15.17. Гүйцэтгэгч ажлыг хугацаанд нь хийгээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй цаашид хугацаанд нь гүйцэтгэх боломжгүй болсон бол захиалагч нийт ажлын хэмжээг гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүй багасгах арга хэмжээ авч болно.

#### **АРВАН ЗУРГАА. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЭРХ ҮҮРЭГ**

- 16.1. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын шугамын доод бүтцийн барилгын ажлыг хийж гүйцэтгэн туршилт, тохируулга хийж хүлээлгэн өгнө.
- 16.2. Зураг төслийн баримт бичгийг нарийвчлан судалж, барилгын ажил гүйцэтгэх нөхцөл байдалтай танилцсаны үндсэн дээр ажлын талбай, талбайн гадна хийгдэх бэлтгэл ажил, байгаль орчны хамгаалалт, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангасан арга хэмжээг тусгасан календарчилсан төлөвлөгөөг боловсруулан Захиалагчтай зөвшлилцсений үндсэн дээр баталж, мөрдлөг болгон ажиллана.



- 16.3. Энэ зүйлийн 16.2-д заасан календарчилсан төлөвлөгөө нь барилгын ажлыг шуурхай төлөвлөж удирдах, гүйцэтгэлийг хангах, хянаж баталгаажулахад ашиглагдах энэхүү гэрээний Хавсралт №5-д заасан салшгүй баримт бичиг болно.
- 16.4. Гүйцэтгэгч нь ажлын талбайд явуулах үйл ажиллагаа, ажил зохион байгуулах арга, хэлбэр нь тодорхой, тогтвортой, хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн стандартыг чанд мөрдүүлж, нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулж, аюулгүй байдлыг бие даан бүрэн хариуцна.
- 16.5. Гүйцэтгэгч нь зураг төслийг хүлээн авмагцаа уг зураг төслийг алдаатай байна гэж үзвэл энэ тухай үндэслэл бүхий саналаа бичгээр гаргах эрхтэй.
- 16.6. Гэрээ байгуулах үед урьдчилан төлөвлөх боломжгүй байснаас ажлын тоо хэмжээ болон төсвийн хэмжээ нэмэгдэх, хасагдах бол Гүйцэтгэгч энэ тухай захиалагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй бөгөөд захиалагч нь тухайн асуудлыг төслийн үндсэн захиалагчтай харилцан зөвшилцэж шийдвэрлэнэ.
- 16.7. Барилгын ажлыг гүйцэтгэх үед гарсан зөрчил, догоолдлыг захиалагчаас тавьсан шаардлагын дагуу бүрэн арилгах үүрэгтэй. Энэхүү эвдрэл гэмтэл нь ажил гүйцэтгэх үеийн технологийн алдаанаас болж гарсан гэж үзвэл Захиалагчтай хамтран шалгах, шаардлагатай гэж үзвэл хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар тогтоолгож болно.
- 16.8. Гүйцэтгэгч нь ажлын талбай дахь бусдын эд хөрөнгө, цахилгаан, сантехникийн тоноглол, шугам, сүлжээ бусад өмчлөл, эд зүйлийг устгасан, эвдсэн, гэмтээсэн, үрэгдүүлсэн бол өөрийн зардлаар тогтоосон хугацаанд сэргээн засварлана.
- 16.9. Гүйцэтгэгч нь ажлын гүйцэтгэлийг батлагдсан зураг төслийн дагуу батлагдсан төсвөөр, календарчилсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж ажлын гүйцэтгэлийг тухай бүр Захиалагчид гэрээнд заасан нөхцөлийн дагуу хүлээлгэн өгнө.
- 16.10. Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой итгэмжлэгдсэн этгээдийг талууд томилно.
- 16.11. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн ажлыг гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгэх ажлын туршлага, ур чадвар бүхий инженер, техникийн ажилтанууд, хүчин чадал бүхий техник, тоног төхөөрөмж, машин механизмыг байна.
- 16.12. Гүйцэтгэгч нь ажлын гүйцэтгэлийн талаар Захиалагчаас шаардсан үед дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй. Захиалагчид урьдчилан мэдэгдэлгүйгээр хуваарьт төлөвлөгөөнд ямар нэгэн өөрчлөлт хийж болохгүй.
- 16.13. Гүйцэтгэгч нь түгээмэл тархацтай ашигт малтмалын орд газрыг ашиглахаар өөрөө нээсэн тохиолдолд шинжилгээний үр дүнг захиалагчид танилцуулах бөгөөд захиалагч нь тухайн ашигт малтмалыг бүтээн байгуулалтын ажилд ашиглахад нийцэх эсэх талаар зөвшөөрлийг төслийн үндсэн захиалагч “Монголын Төмөр зам” ТӨХК-д уламжлан шийдвэрлүүлж зөвшөөрсөн тохиолдолд Гүйцэтгэгч нь тухайн орд газрыг ашиглана.
- 16.14. Гүйцэтгэгч нь түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч, төлбөрийг хариуцна. Тухайн түгээмэл тархацтай ашигт малтмалын орд газар нь холбогдох стандартын дагуу “Монголын Төмөр зам” ТӨХК-аас батласан “Газар шорооны ажлын техникийн шаардлага”-д нийцсэн байна.
- 16.15. Гүйцэтгэгч нь ажлын гүйцэтгэлтэй холбоотой бүх терлийн дээж авах, дүгнэлт гаргах эрх бүхий чанарын шаардлага хангасан лабораторийн байх эсхүл эрх бүхий лабораториор дүгнэлт гаргуулж болно.
- 16.16. Гүйцэтгэгч нь ашиглаж байгаа бүх техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, найдвартай хэвийн ажиллагааг хариуцах ба ажлын талбай дахь тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглана.
- 16.17. Гүйцэтгэгч нь шаардлагатай худаг усыг ашиглах, хамгаалах, худгийн ашиглалтын эвдрэл гэмтэлтэй холбоотой үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
- 16.18. Зэвсэгт хүчний Бүтээн байгуулалтын дэмжлэгийн газар нь худаг устай холбоотой аливаа үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.



- 16.19. Гүйцэтгэгч нь уг гэрээний 16.17-д заасан үүргээ хэрэгжүүлээгүй нь гэрээний хавсралт №5-д заасан гэрээний хугацааг хэтрүүлэх үндэслэл болохгүй.
- 16.20. Захиалагчаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.
- 16.21. Гүйцэтгэгч тал гэрээнд заасан хугацаанд болон уг хугацаанаас өмнө ажлын гүйцэтгэлийг чанарын өндөр түвшинд бүрэн гүйцэтгэж хүлээлгэн өгөх эрхтэй.
- 16.22. Ажил гүйцэтгэх явцад болон хүлээлгэн өгсөний дараа илэрсэн ажлын чанарын доголдол, буруу, дутуу хийгдсэн ажлыг захиалагчийн анхны шаардлагаар тухай бүр өөрийн хөрөнгөөр засаж сайжруулах үүрэгтэй.
- 16.23. Гүйцэтгэгч нь гэрээ болон календарчилсан төлөвлөгөөнд заасан хугацааг чанд баримтлах бөгөөд тогтоосон хугацаанд ажлыг бүрэн хийж хүлээлгэн өгөөгүй тохиолдолд гэрээний Хавсралт №4-д заасан алданги төлнө.
- 16.24. Гүйцэтгэгч нь захиалагчийн өгсөн чиглэл, заавар, зөвлөмжийг биелүүлж, ажлын талбайд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөөг мөрдлөг болгон ажиллана. Энэхүү төлөвлөгөөг мөрдөж ажиллаагүйгээс үүсэн гарсан аливаа хариуцлага, эрсдэлийг гүйцэтгэгч бүрэн хариуцна.

#### **АРВАН ДОЛОО. АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХ, ХОЙШЛУУЛАХ, ТҮР ЗОГСООХ**

- 17.1. Барилгын ажлын магадлагдсан болон техникийн зураг, шаардлага, ажлын даалгаврыг гүйцэтгэгч хүлээн авч улаан шугам татах акт үйлдэж ажлыг эхлүүлнэ.
- 17.2. Гүйцэтгэгч нь дараах шалтгааны улмаас гэрээт ажлын хугацаа хойшлогдохоор бол Захиалагчид энэ тухай бичгээр хүсэлт гаргах эрхтэй бөгөөд хүсэлтэд холбогдох нотлох баримтыг хавсаргана. Үүнд:
- 17.2.1. Эрх бүхий байгууллагын үйл ажиллагаа, тушаал, шийдвэрээс шалтгаалан гүйцэтгэгчийн ажлыг түр хойшлуулсан, saatuulsan;
- 17.2.2. Урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдлаас болж ажил хойшлогдсон, saatuulsan, тасарсан бол захиалагч нь гүйцэтгэгчийн хүсэлт, холбогдох баримтыг үндэслэн гэрээний хугацааг сунгах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.
- 17.3. Захиалагчийн зайлшгүй шаардлагын улмаас өгсөн зааварчилгаа болон гүйцэтгэгчийн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ажлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоож болох ба талууд түр зогсолт хийх болсон үндэслэл шалтгааны талаар харилцан бичгээр мэдэгдэнэ.
- 17.3.1. Гүйцэтгэгч нь гэрээний 17.3-т заасны дагуу захиалагчийн зааварчилгаагаар ажлаа түр зогсоож түүнээс шалтгаалан нэмэлт зардал гарсан, ажлыг хойшлуулахад хүрсэн, ажлаа дахин үргэлжлүүлсэн бол гүйцэтгэгч нь захиалагчид гэрээний хугацааг сунгах тухай мэдэгдлийг хүргүүлж болно.
- 17.3.2. Хэрэв түр зогсолт нь гүйцэтгэгчийн буруутай үйлдэл, эс үйлдэл /ажлын төлөвлөлт, ажилтануудын ур чадвар, материалын чанарын доголдол, түүнчлэн түр зогссон хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын чанар, ажлыг бүхэлд нь эсхүл тодорхой хэсгээр арчлах, элэгдэл, гэмтлээс хамгаалах, материал, техник хэрэгслийн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хангалттай хэрэгжүүлээгүй/-ээс үүссэн тохиолдолд аливаа нэмэлт зардал, төлбөр, хохирлыг гүйцэтгэгч дангаар хариуцах бөгөөд энэ нь гэрээний хугацаа сунгах үндэслэл болохгүй.
- 17.3.3. Түр зогсолтын үед гүйцэтгэгч нь ажлын талбайгаас хүн хүч, техник, тоног төхөөрөмж, багаж, материал хэрэгслийг захиалагчийн зөвшөөрөлгүй нүүлгэн шилжүүлэхийг хориглоно.
- 17.3.4. Гүйцэтгэгчийн алдаатай үйл ажиллагааны улмаас ажлын гүйцэтгэл хангалтгүй гэж үзсэн, ажлыг дахин хийх шаардлага гарсан, ашиглах материал нь элэгдэл, доголдлыг илрүүлж солих, сайжруулах болсноор түр зогсолт хийсэн бол ажил гүйцэтгэлийн хугацааг сунгах, нэмэлт зардал гаргах үүргийг захиалагч хүлээхгүй, энэ тухай гүйцэтгэгч шаардах эрхгүй.

ГҮЙЦЭТГЭГЧ  
ХАРИУЦ

17.3.5. Ажлаа үргэлжлүүлэх зөвшөөрөл /зааварчилгаа/ авсны дараа талууд хамтран түр зогсолтын нөлөөнд автсан ажил, материалыг шалгаж үзнэ. Гүйцэтгэгч түр зогсолтын хугацаанд элэгдсэн, доголдол гарсан, алдагдалд орсон ажил, материалын төлбөрийг хариуцна.

#### **АРВАН НАЙМ. ӨӨРЧЛӨЛТ БОЛОН ТОХИРУУЛГА**


- 18.1. Гүйцэтгэгчийн талаас гаргасан ажилд орох өөрчлөлтийн талаархи санал, ажил гүйцэтгэсэн акт, аргачлал, зааварчилгааг Захиалагчид заавал бичгээр мэдэгдэнэ.
- 18.2. Гүйцэтгэгч нь өөрчлөлтөд шаардлагатай материалыг шуурхай олж чадаагүй, ажлын явц, дараалалд гарах бодит өөрчлөлт үүссэнийг заасан мэдэгдлийг тэр даруй Инженерт хүлээлгэн өгөх бөгөөд бусад тохиолдолд өөрчлөлтийг бие даан хариуцна. Энэхүү мэдэгдлийг хүлээн авсан даруйдаа Инженер нь зааварчилгааг хүчингүй болгох, баталгаажуулах эсвэл өөрчлөх арга хэмжээ авна.
- 18.3. Өөрчлөлт оруулах саналд дараах зүйлс багтана. Үүнд:
- 18.3.1. Гэрээнд заагдсан ажлын тоо хэмжээнд өөрчлөлт орсон;
- 18.3.2. Өөрчлөлтийг инженер баталгаажуулаагүй тохиолдолд хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэгч бие даан хариуцна.
- 18.3.3. Зураг төсөл, техникийн шаардлагад зааснаас бусад нөхцөлд ажилд өөрчлөлт оруулбал Захиалагчийн инженерт заавал бичгээр мэдэгдэж зөвшөөрөл авна.
- 18.3.4. Ямар нэгэн орхигдсон ажил;
- 18.3.5. Ямар нэгэн нэмэлт ажил, байнгын ажилд шаардлагатай үйлдвэр, материал, үйлчилгээ болон туршилт судалгааны ажил;
- 18.3.6. Ажлыг гүйцэтгэх дараалал болон хугацаанд орох өөрчлөлт.
- 18.4. Гүйцэтгэгч нь Захиалагчийн зааварчилсан эсвэл өөрчлөлтийг зөвшөөрөх хүртэл ямар нэгэн ажил, өөрчлөлт хийж болохгүй ба зөвшөөрөлгүй хийсэн ажлын эрсдэл, тооцоог бие даан хариуцна.

#### **АРВАН ЕС. БАРЬЦАА ХӨРӨНГӨ, ТҮҮНИЙГ ЧӨЛӨӨЛӨХ**

- 19.1. Барьцаа хөрөнгө Гэрээний үнийн дунгийн 5 хувьтай тэнцүү хэмжээтэй байх бөгөөд Захиалагч нь ажлын гүйцэтгэлийн төлбөр бүрээс энэ хувь хэмжээгээр суутган үлдээнэ.
- 19.2. Гэрээт ажил бүрэн дууссан тухай Гүйцэтгэгчийн мэдэгдлийг үндэслэн уг гэрээнд заасны дагуу суутгасан үнийн дунгийн 50 хувийг Гүйцэтгэгчид төлөх бөгөөд үлдсэн хэсгийг чанаарын баталгаат хугацаа дууссаны дараа тэр хугацаанд гарсан бүх зөрчил, гологдлыг Гүйцэтгэгч арилгасан тухай Захиалагчийн томилсон Инженерийн мэдэгдэлийг үндэслэн төлнэ.
- 19.3. Хэрэв гүйцэтгэх аливаа ажил үлдсэн тохиолдолд Захиалагч нь тухайн ажлыг гүйцэтгэх хүртэл ажилд хамааралтай тооцсон төлбөрийг saatuuлах эрхтэй.

**ХОРЬ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,  
ЭРҮҮЛ АХУЙ, БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ,  
НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ**

- 20.1. Гүйцэтгэгч нь Захиалагчаас гаргасан загварын дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулж, барилгын ажлын явцад мөрдөж, тухай бүр шинэчлэн нэмэлт өөрчлөлт оруулж захиалагчаар баталгаажуулсан байна.
- 20.2. Гүйцэтгэгч нь гэрээний хэрэгжилтийн хугацаанд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хууль, “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, бусад холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөж, стандартын шаардлага, өөрийн ажиллах хүчний аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндийг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, ажлын байрны эрсдэлийн үнэлгээг тогтоож, аюулгүй орчинг бурдуулж ажиллана.
- 20.3. Захиалагч эсвэл түүний төлөөлөл барилгын ажил гүйцэтгэж байх хугацаанд хэдийд



ч дээр заасан төлөвлөгөөний аливаа гүйцэтгэлийг шалгаж болох ба төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй нь Гүйцэтгэгчийг энэхүү гэрээгээр хүлээсэн аливаа үүрэг хариуцлагаас чөлөөлөхгүй. Энэ бүлэгт заасан бүхий л ажил барилгын төсөвт өртөгт багтсан болно.

#### 20.4. Гүйцэтгэгч нь:

- 20.4.1. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа болон бусад шаардлагыг дагаж мөрдөх;
- 20.4.2. барилгын ажлын талбайд ажиллах бүх ажилчдын аюулгүй байдлыг хангах, хариуцах;
- 20.4.3. гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх;
- 20.4.4. барилгын ажлын талбайд аюул учрахаас урьдчилан сэргийлэх үүднээс барилгын ажлын талбай дээрх шаардлагагүй саадуудыг цэвэрлэх, ажлын талбайг эмх цэгцтэй байлгах;
- 20.4.5. урьдчилсан байдлаар ашиглалтад хүлээн авах хүртэл уг Барилгын ажлыг хашаа, гэрэлтүүлэг, харуул хамгаалалтаар хангах;
- 20.4.6. барилгын ажлыг гүйцэтгэхтэй холбоотойгоор барилгын ажлын талбай болон зэрэглэдээ газар ажиллаж буй хүмүүсийг хамгаалах болон тэдний ашиглахад шаардлагатай байж болох Түр байгууламжууд /зам, явган хүний зам, харуулын байр, хашаа зэрэг/-ыг байгуулах.
- 20.4.7. Гүйцэтгэгч нь байгаль орчныг хамгаалах /Ажлын талбай болон түүний орчин/ сөрөг нөлөөллийг бууруулах болон нөхөн сэргээлт хийх, бохирдол, шуугиан болон түүний үйл ажиллагааны улмаас иргэд ба бусдын өмч хөрөнгөд учруулж болзошгүй хохирол, хүндрэлийг хязгаарлах талаар шаардлагатай бүх арга хэмжээг авна.
- 20.4.8. Гүйцэтгэгч нь түүний үйл ажиллагааны улмаас хорт бодис, хий ялгаруулалт болон газрын гадаргуу дээрх бохир усны урсгал нь холбогдох хуульд заасан хэм хэжээнээс хэтрэхгүй байх, байгаль орчныг бохирдуулахгүй байх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

20.5. Гүйцэтгэгч нь Барилгын ажлын талбайд үйл ажиллагаа явуулахтай холбоотой дараах журмыг баталсан байна. Үүнд:

- 20.5.1. Ажлын талбайн харуул хамгаалалт;
  - 20.5.2. Шалгах нэвтрүүлэх хяналт;
  - 20.5.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байдлыг хангах, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах;
  - 20.5.4. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх.
- 20.6. Гүйцэтгэгч нь тухайн орон нутгийн эрүүл мэндийн эрх бүхий байгууллагатай хамтран ажиллаж, эмнэлгийн ажилтан, эмнэлгийн анхан шатны яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх, эмчилгээний өрөөг ажлын талбайд болон Гүйцэтгэгч, Захиалагчийн ажилчдын аливаа амьдрах байр /Кэмп/-нд байнга бэлэн байлгах, аливаа халдварт өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг хамгаалах, эрүүл ахуйг хангах зайлшгүй шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 20.7. Гүйцэтгэгч нь ажлын талбайд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй /ХАБЭА/, байгаль орчны асуудал хариуцсан албан тушаалтанг томилж, үүрэг даалгавраар хангаж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдүүлж ажиллуулна. ХАБЭА-н асуудал хариуцсан албан тушаалтан нь мэргэжлийн шаардлага хангасан, холбогдох сургалт, дамжааг дүүргэсэн байх ба хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, гэмт хэрэг, үйлдвэрлэлийн аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, бүх төрлийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа танилцуулах, мөрдүүлэх, хяналт тавих эрхтэй байна. Барилгын ажлыг гүйцэтгэх явцад Гүйцэтгэгч нь дээрх албан тушаалтанд ажил, үүргээ хэрэгжүүлэхэд саад учруулахыг хориглоно.
- 20.8. Гүйцэтгэгч нь ямар нэгэн хэрэг, осол, зөрчил гармагц нэн даруй болсон үйл явдлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг Захиалагчид албан бичгээр болон утсаар дамжуулна.

Гүйцэтгэгч нь Захиалагчаас гаргасан загварын дагуу ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, эд хөрөнгийн гэмтэл хохирлын буртгэл хөтөлж, ажилчдын тайланг Захиалагчийн шаардсан байдлаар гаргаж өгч байна.

20.9. Гүйцэтгэгч байгаль орчин болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр дараах нарийвчилсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

20.9.1. Байгаль орчны чиглэлээр:

20.9.1.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангах, сар бүр тайлagnах.

20.9.1.2. Ухмал буюу сэтэрхийгээс гарсан шороог орон нутгийн болон захиалагчийн зөвшөөрсөн цэгт хаях, овоолгуудыг байгалийн төрхөнд зохицуулан хэлбэржүүлэх.

20.9.1.3. Далангийн дүүргэлт болон технологийн зам, түр замд ашиглаж байгаа шороон ордуудын байршил нөөцийг тогтоон, орон нутгаас зөвшөөрөл авах хүсэлтийг ерөнхий гүйцэтгэгч болон захиалагчид өгөх.

20.9.1.4. Орон нутгийн хот тохижилтийн байгууллагатай ахуйн болон аюултай хог хаягдлын гэрээ байгуулан ажиллах, холбогдох төлбөрийг төлөх.

20.9.1.5. Шороон ордыг нээж олборлолтыг эхлүүлэх болон ашиглалтын нөөц дууссан шороон ордуудыг нөхөн сэргээхдээ Монгол Улсын MNS5616:2008, MNS5917:2008 стандарт болон бусад норм, техникийн шаардлагыг мөрдөж ажиллах.

20.9.1.6. Ашиглаж буй болон ашиглалтын нөөц дууссан шороон ордуудын хаалт хамгаалалт, тэмдэг тэмдэглэгээг хийж аюулгүй байдлыг хангах,

20.9.1.7. Ашиглаж буй худгуудын засвар үйлчилгээг хийх, ус зарцуулалтанд хяналт тавин ус ашиглалтын бүртгэлийг хөтлөх, худгийн эргэн тойронд үүсч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж арга хэмжээ авах.

20.9.1.8. Карьер, худаг, кемпийн орчмын 500 метрт хог хаягдлыг цэвэрлэх, аюултай буюу машин механизм, тээврийн хэрэгслээс гарсан хог хаягдлыг бүртгэл хөтлөн тээвэрлэж зөвшөөрөгдсөн цэгт хаях.

20.9.1.9. Байршил заасан бүдүүвч зурагтай байх /кемп, хогын цэг, карьер, ухмалын овоолго г.м/.

20.9.2. Хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр:

20.9.2.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах, сар бүр тайлagnах.

20.9.2.2. ХАБЭА-н баримт бичгийн бүрдлийг хангах, холбогдох дүрэм, журмыг мөрдөх, алба хаагч, ажилчдад танилцуулах, гарын үсгээр баталгаажуулах.

20.9.2.3. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг танилцуулах, гарын үсэг зуруулан баталгаажуулах.

20.9.2.4. Ажилтан, албан хаагчдыг улиралд бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулах, эрүүл ахуйн дүрэм, журмыг мөрдөх,

20.9.2.5. Кэмпүүдэд анхны тусlamжийн иж бүрдлээр хангах,

**ХОРИН НЭГ. УРЬДЧИЛАН ХАРАХ БОЛОМЖГҮЙ ХҮНДРЭЛ**

21.1. Гүйцэтгэгч барилгын ажилд нөлөөлж болох эрсдэл, цаг агаарын нөхцөл байдал, магадлашгүй зардал болон бусад нөхцөл байдалтай холбоотой шаардлагатай бүх мэдээллийг судалж мэдсэн байна.

**ХОРИН ХОЁР. ХӨНДЛӨНГИЙН НӨЛӨӨЛӨЛ  
ҮЗҮҮЛЭХЭЭС ЗАЙЛСХИЙХ**

22.1. Гүйцэтгэгч нь:

22.1.1. олон нийт, орон нутгийн иргэдийн амгалан тайван байдал, захиалагчийн эсвэл бусдын эзэмшлийн байхаас үл хамааран бүх төрлийн зам, замын байгууламж, бусдын



эзэмшил, өмчлөлд нэвтрэх, эвдэх, гэмтээх, устгах, тэдгээрийг ашиглах, хэрэглэх, эзэмшихэд шаардлагагүйгээр эсвэл зохисгүйгээр хөндлөнгөөс саад учруулахгүй байна;

22.1.2. Гүйцэтгэгч нь тийнхүү шаардлагагүйгээр эсвэл зохисгүйгээр хөндлөнгийн саад учруулснаас үүдэн гарах бүх хохирол, алдагдал болон зардлыг нөхөн төлж хохирлыг барагдуулна.

## 22.2. Захиалагч нь:

22.2.1. Гэрээгээр хийж гүйцэтгэж буй ажилтай холбогдуулан иргэдийн эсэргүүцэл, бослого, жагсаал, цуглааныг Захиалагч зохицуулах бөгөөд энэ төрлийн аливаа хөндлөнгийн нөлөөлөл гүйцэтгэгчид учрахаас урьдчилан сэргийлэн ажиллана.

## ХОРИН ГУРАВ. АЖЛЫН ЯВЦЫН ТАЙЛАН

23.1. Гүйцэтгэгч нь өөрийн хийж гүйцэтгэсэн барилгын ажлын явцын тайланг бэлтгэн албан бичгээр, эх хувиар 4 хувь, цахим хэлбэрээр 1 хувийг Захиалагчид хүлээлгэн өгнө.

23.2. Барилгын ажлын явцын анхны тайлан нь ажил эхлэх өдрөөс хойш эхний хуанлийн сарын эцэс хүртэлх хугацааг хамаарна. Тайланг түүнээс хойш сар тутам гаргах бөгөөд тайлан бүрийн хамрах хугацааны сүүлчийн өдрөөс хойш 5 хоногийн дотор өгнө.

23.3. Барилгын ажлыг хүлээн авсан баримтад хийгдээгүй үлдсэн бүх ажлыг Гүйцэтгэгч хийж дуустал тайлангийн хугацаа үргэлжилнэ.

23.3.1. Тайлан нь дараах зүйлсээс бүрдэнэ. Үүнд:

23.3.1.1. гүйцэтгэгчийн баримт бичиг, худалдан авалт, үйлдвэрлэл, барилгын ажил, туршилтын талаар оруулж, ажлын гүйцэтгэлийн бүдүүвчийг хавсаргах, мөн туслан гүйцэтгэх гэрээгээр хамтран оролцож буй гүйцэтгэгчийн ажил тус бүрийг;

23.3.1.2. зураг төсөл, үйлдвэрлэл, ажлын талбайд хүргэлт болон туршилтын үе шат бүрийг багтаасан ажлын явцын бүдүүвч болон нарийвчилсан танилцуулга;

23.3.1.3. үйлдвэрлэлийн явц болон ажлын талбай дээрх ажлын явцыг харуулсан гэрэл зураг;

23.3.2. Материалын гол зүйл тус бүрийн үйлдвэрлэлийн хувьд үйлдвэрлэгчийн нэр, үйлдвэрлэгчийн байршил, үйлдвэрлэлийн явцын хувь, хэмжээ болон дараах зүйлсийн бодит эсвэл төлөвлөж буй хугацаа:

23.3.2.1. үйлдвэрлэл эхлэх;

23.3.2.2. гүйцэтгэгчийн үзлэг, шалгалт;

23.3.2.3. туршилтууд;

23.3.2.4. тээвэрлэлт болон ажлын талбайд ирэх.

23.3.3. Ажиллах хүн хүч, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бүртгэл, судалгаа, дэлгэрэнгүй мэдээлэл;

23.3.4. Чанарын баталгаажуулалтын баримт бичиг, материалын туршилтын үр дүн, материалын гэрчилгээний хуулбар;

23.3.5. Захиалагч болон гүйцэтгэгчийн гаргах мэдэгдэлүүд болон тэдгээрийн жагсаалт;

23.3.6. Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа, олон нийтийн харилцааны талаарх аюулгүй байдалтай холбоотой мэдээлэл;

23.3.7. Төлөвлөгдсөн болон бодит ажлын гүйцэтгэлийн харьцуулалт, онцлог, үйл явдал, Гэрээний дагуу ажлыг дуусгахад үүсч буй бэрхшээл, нөхцөл байдал, хоцорч буй ажлуудыг дуусгах арга хэмжээ.

## ХОРИН ДӨРӨВ. АЖЛЫН ТАЛБАЙ, КЭМПИЙН ХАРУУЛ ХАМГААЛАЛТ

24.1. Ажлын талбайн кэмпийн харуул хамгаалалтыг Гүйцэтгэгч хариуцна.

24.2. Гүйцэтгэгч нь зохих зөвшөөрөлтэй этгээдийг ажлын талбай, кэмпт нэвтрүүлнэ.

24.3. Нэвтрэх эрх бүхий хүмүүс, тээврийн хэрэгслийн талаар мэдээллийг талууд харилцан мэдэгдсэн байна.



## ХОРИН ТАВ. ДААТГАЛ

- 25.1. Гүйцэтгэгч нь холбогдох хууль тогтоомжийн дагуу ажилчид, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бараа материалыг даатгалд хамруулсан байна. Үүнд: ажиллагсадыг эрүүл мэндийн, нийгмийн даатгал, нөхөн олговор, үндсэн ба туслах техник хэрэгсэл, гуравдагч этгээдийн өмнө хүлээх тээврийн хэрэгслийн хариуцлагын даатгал, мэргэжлийн хариуцлагын даатгалд бусад холбогдох даатгалд хамруулсан байна.
- 25.2. Ийнхүү даатгуулаагүйгээс гарах аливаа үр дагаврыг Захиалагч болон гуравдагч этгээдийн өмнө гүйцэтгэгч бүрэн хариуцна.
- 25.3. Гүйцэтгэгч нь барилгын ажил гүйцэтгэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журам, зааварт заасан аливаа даатгал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэхтэй холбогдон гарах зардлыг бүрэн хариуцна.

## ХОРИН ЗУРГАА. АЖЛЫН ТАЛБАЙ

- 26.1. Гүйцэтгэгч нь өөрийн үйл ажиллагааг барилгын ажлын талбайн хүрээнд явуулна.
- 26.2. Барилгын ажлын талбайд геодезийн үндсэн сүлжээ болон өндөржилт, геодезийн үндэслэлийг газар дээр нь тогтоосон баримт бичгийг хүлээн авах зэрэг дараах ажлыг явуулна. Үүнд:
- 26.2.1. Геодезийн тэг тэнхлэг татах;
  - 26.2.2. Барилгын талбайг цэвэрлэх, чөлөөлөх;
  - 26.2.3. Талбайг тэгшлэх, зайлшгүй шаардлагатай тохиолдолд ус, намгийг хатаах, хөрсний усны төвшинг доошуулах;
  - 26.2.4. Инженерийн шугам сүлжээ /ус, дулаан, цахилгаан/-г шинээр бий болгох, холболт хийх, хугацааг тогтоох;
  - 26.2.5. Барилгын ажлын талбай дахь технологийн замыг ашиглах, талбайг барих;
  - 26.2.6. Талбайг хашиж хамгаалах, шалган нэвтрүүлэх тогтолцоог бий болгох;
  - 26.2.7. Үйлдвэрлэлийн шуурхай удирдлага, холбоог бий болгох;
  - 26.2.8. Барилгын ажлын талбайг гал түймрийн аюулаас хамгаалах тогтолцоонд хамруулж, талбайн хамгаалалтын гэрэлтүүлэг ба дохиолол хамгаалалтын сүлжээ бий болгох;
  - 26.2.9. Барилгын ажлын талбайг нөхөн сэргээх зэрэг ажил хамаарна.
- 26.3. Талбайн түр ажилд дараах ажил багтана. Үүнд:
- 26.3.1. Туслах чанарын зам /технологийн/ тавих;
  - 26.3.2. Цахилгааны салбар шугам татах, холбох,
  - 26.3.3. Туслах болон түр барилга байгууламжийг барих зэргийг хамруулна.
- 26.4. Барилгын ажлын талбайд Гүйцэтгэгч нь уг ажлыг гүйцэтгэхдээ холбогдох орон нутгийн засаг захиргаа, газрын болон хот байгуулалт, геодези, кадастрын зургийн байгууллага, авто ба төмөр зам, инженерийн шугам сүлжээний /ус, дулаан, цахилгаан/ холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллах бөгөөд тэдгээр байгууллагатай ашиглалт, үйлчилгээний гэрээ байгуулна.
- 26.5. Гүйцэтгэгч нь өөрийн ажилчид, техник, тоног төхөөрөмж, бараа материалын байршуулалт, хадгалалт, хамгаалалт, барилгын ажлын талбайд үйл ажиллагаа явуулах зохион байгуулалтын бүх арга хэмжээг авна.
- 26.6. Гүйцэтгэгч нь Барилгын ажлын талбай болон барилгын ажлын үйлдвэрлэлийн орчны эмх цэгц, аюулгүй байдлыг хангаж, нөхөн сэргээлтийг гүйцэтгэж ажиллана.
- 26.7. Нутгийн захиргааны байгууллагын зохих албадтай тохиролцсоноор барилгын хог, хаягдлыг нэр төрлөөр нь тусгайлан ангилж хаях цэгийг тогтоох бөгөөд барилгын талбайд хог цуглуулах ба машин техникийг угаах цэг байгуулж, тухайн газрын арчилгаа, цэвэрлэгээг хариуцна.
- 26.8. Барилгын талбайн гаднах нутаг дэвсгэрийг барилгын зориулалтаар түр

хугацаагаар ашиглах талаар нутгийн захиргаатай тохиролцох ба иргэд, мал, ан амьтны аюулгүй байдлыг хангах болон байгаль орчны тэнцвэрт харьцааг хангах нөхцлийг тодорхойлж гэрээ байгуулна.

26.9. Гүйцэтгэгч нь хүрээлэн буй байгаль орчны байгалийн тэнцвэрт байдлыг хадгалах, орон нутгийн иргэд, мал, ан амьтныг аюулгүй амьдрах нөхцлийг хангана.

#### **ХОРИН ДОЛОО. ЗУРАГ ТӨСЛИЙН АЛДАА**

27.1. Зураг төсөл, түүнтэй холбоотой бусад баримт бичгүүдэд алдаа, орхигдуулсан эсвэл тодорхойгүй зүйл илрвэл Захиалагчид нэн даруй мэдэгдэх бөгөөд захиалагч нь зураг төсөл зохиогчтой зөвшилцэн зураг төслийн алдааг засварлуулах арга хэмжээг авч болно.

#### **ХОРИН НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

28.1. Гэрээт ажлуудыг гүйцэтгэх явцад болон гэрээ дуусгавар болсон, цуцлагдсаны дараа захиалагч болон гүйцэтгэгч талуудын хооронд маргаан үүссэн нөхцөлд талууд эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

28.2. Хэрэв маргаантай асуудлаар талууд тохиролцоонд хурч чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### **ХОРИН ЕС. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ**

29.1. “Давагдашгүй хүчин зүйл” гэдэгт гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш үүссэн, аль нэг талыг гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд саад болох бүхий л асуудлыг хэлэх бөгөөд гэрээний талууд хяналт тавих, урьдчилан таамаглах, зайлсхийх болон даван гарах боломжгүй асуудалд газар хөдлөлт, үер, усны гамшиг, хүчтэй салхи, шуурга, хүн, мал, ан амьтаны гоц халдварт өвчин, үргэлжилсэн бороо, гал түймэр, дайн, зэвсэгт мөргөлдөөн, онц байдал, жагсаал, цуглаан, эмх замбараагүй байдал, эсхүл олон улсын бизнесийн жишгээр давагдашгүй хүчин зүйл хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн бусад үйл явдал орно.

29.2. Хэрэв давагдашгүй хүчин зүйл тохиолдвол аль ч тал дээр дурдсан нөхцөл байдал бий болсон гэж үзэн гэрээний хугацааг сунгах ба сунгасан хугацаа нь зогсолтын хугацаатай тэнцэнэ. Үүнд алданги, торгуулийн төлбөр төлөхөөс чөлөөлөгднө.

29.3. Давагдашгүй хүчин зүйл тохиолдсоныг мэдэгдэж буй тал нэн даруй албан бичгээр нөгөө талдаа мэдээлэх хэрэгтэй ба мэдэгдсэнээс хойш 14 хоногийн дотор давагдашгүй хүчин зүйл тохиолдсон, үргэлжлэх хугацааны талаар нотлох баримтыг бүрдүүлж хүргүүлнэ.

29.4. Давагдашгүй хүчин зүйлд өртсөн тал түүний нөлөө зогссон даруйд энэ тухай нөгөө талд мэдэгдэнэ.

#### **ГҮЧ. ХҮНД НӨХЦӨЛ БАЙДАЛ**

30.1. Дараах нөхцөл байдлыг хүнд нөхцөл байдал гэж үзнэ. Үүнд:


30.1.1. Засгийн газрын 2019 оны 135 дугаар тогтоол зохих ёсоор хэрэгжээгүйн улмаас уг тогтоолд заасан төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулах төслийн төсөв төвлөрөөгүй, тасалдсан, үүнтэй холбоотойгоор барилгын ажил зогссон, гүйцэтгэсэн ажлын төлбөрийг төлөх боломжгүй болсон.

30.1.2. Гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, Улсын Их хурал, Засгийн газрын шийдвэрт өөрчлөлт орсон, эсхүл шинээр гарсан нь төмөр замын бүтээн байгуулалтын ажил saatax буюу зогсох үндэслэл болсон.

30.2. Хүнд нөхцөл байдал тохиолдсон бол уг гэрээний 29 дүгээр зүйл “Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл”-д заасантай нэгэн адил хамаарна.

30.3. Захиалагч нь гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэх ажлын тоо хэмжээ, барилгын төсвийг төвлөрсөн санхүүжилт, хөрөнгийн эх үүсвэрийг урьдчилан тооцоолж, уг эх үүсвэрээс илүү гарах ажлыг гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.

30.4. Гэрээний 30.1 дэх хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд захиалагч төвлөрсөн хөрөнгийн эх үүсвэр гүйцэтгэгчийн дараагийн үе шатны ажлын төсөвт



хүрхээргүй болсон тохиолдолд нэн даруй энэ тухай гүйцэтгэгчид мэдэгдэж, ажлын гүйцэтгэлийг хүнд нөхцөл байдлын хугацаанд зогсоох үүрэгтэй.

30.5. Гэрээний 30.1 дэх хэсэгт заасан нөхцөл байдал нь гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг барилгын төсөвт батлагдсан үнэлгээгээр төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

### **ГУЧИН НЭГ. ГЭРЭЭГ ДУУСГАВАР БОЛГОХ ЦУЦЛАХ БОЛОН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРАМ**

31.1. Гэрээ дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:

- 31.1.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэнээр;
  - 31.1.2. Талууд харилцан тохиролцсоноор;
  - 31.1.3. Хууль буюу гэрээнд заасан үндэслэлээр аль нэг тал гэрээг цуцалсан тохиолдолд.
- 31.2. Дараах тохиолдолд захиалагч нь гүйцэтгэгчийн саналыг үл харгалзан гэрээг цуцлах арга хэмжээг авна. Үүнд:
- 31.2.1. Барилгын ажлыг тогтоосон хугацаанд эхлүүлээгүй, барилгын ажил нь гүйцэтгэгчээс шалтгаалан тодорхойгүй хугацаагаар зогссон;
  - 31.2.2. Гэрээний хавсралт №5-д заасан барилгын ажлын календарчилсан төлөвлөгөөнөөс ажлын гүйцэтгэл нь хоцорсон, удаа дараа saatсан;
  - 31.2.3. Батлагдсан зураг төсөл, техникийн болон ажлын зураг, даалгавар, нөхцөл зөрчсөн;
  - 31.2.4. Гүйцэтгэгч нь гэрээний аль нэг үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй хайхрамжгүй хандсан;
  - 31.2.5. Гүйцэтгэгч тал нь ажил гүйцэтгэх гэрээгээр хүлээсэн ажлыг захиалагчийн зөвшөөрөлгүйгээр бүрэн болон хэсэгчлэн туслан гүйцэтгэгчид шилжүүлсэн;
  - 31.2.6. Удирдамж, зааврын дагуу буруу хийсэн, дутуу хийсэн, орхигдсон ажлуудыг гүйцэтгээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй, гүйцэтгэхээс татгалзсан бол;
  - 31.2.7. Хуулийн дагуу өр, төлбөрөө төлөх санхүүгийн чадваргүй болсон, сайн дураар болон санамсаргүй дампуурсан, татан буугдсан, тарсан, төлбөрийн чадваргүй болсон гэж захиалагч үзсэн бол;
  - 31.2.8. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх гэрээний барьцааг суутгуулахаас татгалзсан;
  - 31.2.9. Захиалагчийн шаардсан хугацааны дотор даатгалын гэрээг ирүүлээгүй.
  - 31.2.10. Ажил хойшлогдсоныг үлмаас алдагдал, хохиролд хүрсэн бол.
- 31.3. Захиалагчаас гүйцэтгэгч талд гэрээг цуцлах талаар тэр даруй бичгээр мэдэгдэл өгч, ажил гүйцэтгэх гэрээг цуцалж болох ба үүний дараа ажил гүйцэтгэх гэрээний зорилтыг хангахаар гүйцэтгэгчээс талбайд авчирсан бүх техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, материал, бараа бүтээгдэхүүн, бусад зүйлүүдийг захиалагч эзэмшиж болно, захиалагч гэрээнд заасан төлбөрийг барагдуулах зорилгоор худалдаж өөрт учирсан хохирлыг барагдуулж болно.
- 31.4. Гэрээний 31.1-д заасан үндэслэлээр гэрээ дуусгавар болсон тохиолдолд талууд акт үйлдэж, ажлын гүйцэтгэлийг Захиалагчид хүлээлгэж өгнө.
- 31.5. Гэрээ дуусгавар болсон тохиолдолд аль буруутай тал нь гэрээ цуцалсанаас үүссэн хариуцлагыг бүрэн хариуцна.
- 31.6. Гэрээний хугацаанд гэрээг өөрчлөх буюу урьдчилан мэдэгдэх боломжгүй нөхцөл байдал бий болж зайлшгүй өөрчлөлт орох шаардлагатай болсон тохиолдолд талууд харилцан тохиролцож, ажлын хүрээ, хугацаа болон барилгын төсөвтэй холбогдох шаардлагатай засвар, өөрчлөлтийг цаг тухайд нь оруулахыг эрмэлзэнэ.
- 31.7. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр хийж эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж тамга дарагдсанаар хүчин төгөлдөр болно.
- 31.8. Нэмэлт өөрчлөлтуүд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг бөгөөд Үндсэн гэрээний хамт

хүчин төгөлдөр байна.

31.9. Захиалагчийн санаачилгаар гэрээг цуцлах үндэслэл бий болсон бол захиалагч энэ тухай гүйцэтгэгчид бичгээр мэдэгдэл өгч гүйцэтгэгчийг ажлын талбайгаас гаргана.

31.10. Гэрээг цуцалсны дараа гүйцэтгэгч нь ажлын талбайг чөлөөлж, шаардлагатай бараа, материал, гүйцэтгэгчийн бүх баримт бичиг, өөрийн боловсруулсан зураг төсөл бусад бичиг баримтыг захиалагчийн хяналтад, инженерт хүлээлгэн өгнө.

31.11. Гэрээг цуцалсны дараа захиалагч гүйцэтгэсэн ажлын төсөвт өртөг, үлдсэн ажлын тоо хэмжээ, бараа материал, гүйцэтгэгчийн баримт бичгийн үнэлгээг хийнэ.

31.12. Захиалагч нь гэрээт ажлын хугацаа хэтэрсэн алданги, торгууль, илэрсэн зөрчил, эвдрэл, гэмтлийг зассан, эсхүл ажлыг гүйцэтгэсэн зардал болон захиалагчийг эрсдэлд оруулах бусад бүх зардлыг тогтоох хүртэл дараагийн төлбөрийг гүйцэтгэгчид олгохгүй.

31.13. Гүйцэтгэгчид төлөх ёстой ямар нэгэн төлбөрийн мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлыг гүйцэтгэсэн зардлаас захиалагчийг эрсдэлд оруулах хохирол, алдагдлыг нөхөн төлүүлэх ба эдгээр шууд зардал, хохирол, алдагдал, алдангийг нөхөн тооцож, тооцоо нийлсэн төлбөрөөс суутган үлдэгдэл төлбөрийг гүйцэтгэгчид төлнө.

#### **ГҮЧИН ХОЁР. ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОГЧИЙН ЭРХ**

32.1. Барилгын ажлын зураг төсөлд тухайн зураг төсөл зохиогч нь "Барилгын ажилд зохиогчийн хяналт хийх дүрэм"-ийн дагуу хяналт тавина.

32.2. Зохиогчийн хяналт хийх үед барилгын ажилд дүгнэлт өгч, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар санамжийг барилгын ажлын тэмдэглэлд бичиж, гарын үсгээр баталгаажуулах ба шаардлагатай гэж үзвэл зохиогчийн хяналтын дүгнэлтийг Захиалагч болон мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэж зохих арга хэмжээг авна.

#### **ГҮЧИН ГУРАВ. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА**

33.1. Гүйцэтгэгч энэхүү гэрээнд заасан хугацаанд үүрэгт ажлыг эцэслэн дуусгаагүй, хүлээлгэж өгөөгүй тохиолдолд гүйцэтгээгүй үргийн үнийн дүнгийн 0.1 хувийн алдангийг Хавсралт №4-д заагдсан шатлалын дагуу төлнө.

33.2. Календарчилсан төлөвлөгөөг хуанлийн 7 хоногийн хугацаатайгаар дүгнэж, төлөвлөгөөний хоцрогдлыг дараагийн хуанлийн 7 хоногт нөхөн гүйцэтгэх байдлаар талууд харилцан тохиролцсон тохиолдолд үндсэн ажлын тоо хэмжээг бууруулахгүй. Ажлын тоо хэмжээг тохиролцож чадаагүй буюу нөхөн гүйцэтгээгүй тохиолдолд хоцрогдлын зөрүүг үлдсэн хоногт үржүүлж нийт ажлын тоо хэмжээнээс хасна.

33.3. Талууд гэрээнд заасан үүргээ зөрчсөний улмаас учирсан хохирлыг нөгөө талдаа нөхөн барагдуулж, бүрэн хариуцан арилгана.

#### **ГҮЧИН ДӨРӨВ. МЭДЭЭЛЛИЙГ АЛБАН ЁСООР СОЛИЛЦОХ**

34.1. Гэрээний талууд үйл ажиллагаа явуулахад шаардлагатай мэдээллийг харилцан солилцож байна.

34.2. Захиалагч: Зэвсэгт хүчний Жанжин штаб /Зэвсэгт хүчний Бүтээн байгуулалтын дэмжлэгийн газар.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх, 5-р хороо /13340/, Энхтайваны өргөн чөлөө -51.

Утас: 70152661, 11452933

И-мэйл: [bbdg\\_demjileg@mil.gov.mn](mailto:bbdg_demjileg@mil.gov.mn)

34.3. Гүйцэтгэгч: "Ширхэнцэг хараа" ХХК.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, Туул гол, 87, 3/86 тоот

Утас: 96964148, 91919263

И-мэйл: [shirkhentsegkharaa@gmail.com](mailto:shirkhentsegkharaa@gmail.com)

34.4. Мэдээлэл, бичиг баримт, албан бичгийг биечлэн хүлээлгэн өгсөн бол баримт авах бөгөөд цахим шуудан ба шуудангаар зэрэг электрон дамжуулах аргаар хүргүүлж болно.

34.5. Энэхүү гэрээний 34.2, 34.3-т заасан хүлээн авагчийн хаягаар хүргүүлэх, явуулах, дамжуулах үед:



- 34.5.1. Хэрэв хүлээн авагч нь өөр хаяг руу явуулж байх тухай мэдэгдэл өгсөн бол тухайн мэдэгдэл авснаас хойш мэдэгдсэн хаяг руу нь явуулна;
- 34.5.2. Хэрэв хүлээн авагч нь зөвшөөрөл, баталгаа хүсэхдээ өөрөөр тусгайлан заагаагүй бол хариуг тухайн хүсэлт ирүүлсэн хаяг руу нь явуулж болно;
- 34.6. Талууд мэдээллийг түргэн, шуурхай солилцох үүднээс цахим шуудангаар харилцаж, баримт бичгийг эх хувиар давхар хүргүүлнэ.
- 34.7. Захиалагч нь Гүйцэтгэгчийн хүсэлтийн дагуу ажил гүйцэтгэхэд шаардлагатай мэдээ, баримт, зааварчилгааг гарган өгч болно.

#### ГУЧИН ТАВ. БУСАД ЗҮЙЛ

- 35.1. Гэрээнд тусгайлан зааснаас бусад тохиолдолд гэрээ нь талуудын хооронд аливаа эрх зүйн хамаарлыг бий болгохгүй бөгөөд аль нэг тал нь негөө талыг аливаа хэлбэрээр захирах эрхийг үл олгоно.
- 35.2. Гэрээгээр шууд зохицуулаагүй боловч гэрээний хэрэгжилттэй холбогдон гарах аливаа харилцааг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
- 35.3. Гэрээний аль нэг зүйл, хэсэг, заалтын хүчин төгөлдөр бус, хууль бус эсхүл мөрдөхгүй болсон нь гэрээний бусад зүйл, заалтын хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй.
- 35.4. Энэхүү гэрээг Монгол хэл дээр 3 хувь үйлдэж, 1 хувийг гүйцэтгэгч, 2 хувийг захиалагч хадгална.
- 35.5. Гүйцэтгэгч тап нь төрийн эрх бүхий байгууллагаар “Аюулгүй байдлын гэрчилгээ”-г гаргуулна.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

##### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ББДГ-ЫН ЗАМ, ЗАМЫН  
БАЙГУУЛАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА,  
ХУРАНДАА  Д.ЭНХЦОГ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ББДГ-ЫН  
САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ  
ХУРАНДАА  Ц.БАЯРГЭРЭЛ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ББДГ-ЫН  
ХУУЛИЙН ТАСГИЙН ДАРГА  
 П.БАЯНБААТАР

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ББДГ-ЫН ТАСФВЧИН  
ДЭСЛЭГЧ  О.БААСАНСҮРЭН

Утас: 70152661.  
Хаяг: Улаанбаатар хотын 53Д, Энхтайваны  
өргөн чөлөө 51.  
И-мэйл: bbdg\_demjleg@mil.gov.mn



Хаяг: Монгол Улс, Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, Туул гол, 87, 3/86 тоот

Утас: 96964148, 91919263

И-мэйл: shirkhentsegkharaa@gmail.com

Банк: Хаан

Дансны дугаар: 5027859965

Регистрийн дугаар: 5732476